



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 29 өдөр

Дугаар A/40.

Арвайхээр сум

Г Нутгийн захиргааны байгууллагын 2023 оны үйл ажиллагааны үр дүнд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгийн тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, аймгийн Засаг даргын 2021 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн А/342 дугаар захирамжаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.11.а, 9.11.б, 9.12, 10 дугаар зүйлийн 10.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нутгийн захиргааны байгууллагын 2023 оны үйл ажиллагааны үр дүнд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр тэргүүлсэн Бат-Өлзий, Хархорин, Есөнзүйл, Өлзийт, Гучин-Ус сумдыг тус бүр 3,000,000 (гурван сая) төгрөг, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Нийгмийн даатгалын хэлтэс, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Улсын бүртгэлийн хэлтсийг тус бүр 2,000,000 (хоёр сая) төгрөгөөр шагнасугай.

2. Шагналын зардалд шаардагдах 21,000,000 (хорин нэгэн сая) төгрөгийг аймгийн Засаг даргын Нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

3. Үйл ажиллагааны дүнгээр тэргүүлсэн Бат-Өлзий, Хархорин, Есөнзүйл, Өлзийт, Гучин-Ус сумдын Засаг дарга, түүний Тамгын газрын дарга наарт, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Нийгмийн даатгалын хэлтэс, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Улсын бүртгэлийн хэлтсийн дарга наарт тус бүр нэг сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг тухайн байгууллагын төсвөөс олгохыг нягтлан бодогч наарт зөвшөөрсүгэй.

ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



И.ДОРЖСҮРЭН

8224 11 0147